



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

᠒᠐᠒᠒ оны ᠐5 сарын ᠒᠒ өдөр

Дугаар А/᠑5

Мандалговь

“Классик роуд” ХХК-тай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/27 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн “Аймгийн төвийн 19км орон нутгийн авто замын засварын ажлын зураг, төсөв боловсруулах ” ажлыг 19,500,000 (арван есөн сая таван зуу) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн үнийн саналаар “Классик роуд” ХХК-тай 19,500,000 (арван есөн сая таван зуу) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зургийн даалгаврын дагуу “Аймгийн төвийн 19км орон нутгийн авто замын засварын ажлын зураг, төсөв боловсруулах ” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Классик роуд” ХХК-ийн захирал (Ч.Төгсбат)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Л. ДОРЖБАТ



4822150212